



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/37

Улаанбаатар хот

**Эргүүлийн үүрэг гүйцэтгүүлэх ажлыг
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, архидан согтуурахтай тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс 2026 оны 04 дугаар сарын 23-ний өдрийг хүртэл байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтнуудыг оролцуулсан эргүүлийг зохион байгуулсугай.

2.Байгууллага, аж ахуйн нэгжийн эргүүлээр ажиллах хуваарийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Батлагдсан хуваарийн дагуу эргүүлд үүрэг гүйцэтгэх ажилтан, алба хаагчдыг томилон ажиллуулахыг байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч нарт, үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Цагдаагийн хэлтэс (Цагдаагийн хурандаа Т.Лхагвасүрэн)-т, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлан ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т тус тус үүрэг болгосугай.

4.Эргүүлээр ажиллахад шаардагдах 64,000 (жаран дөрвөн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 03 дугаар сарын 06 –ны өдрийн
А/З... дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



“ЭРГҮҮЛ АЖИЛЛУУЛАХ” АРГА ХЭМЖЭЭНИЙ
ХҮРЭЭНД ЗАРЦУУЛАХ ТӨСӨВ

д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хантааз	ш	4	16,000	64,000
Нийт дүн					64,000